



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 11 дүгээр
сарын 23-ны өдөр

Дугаар 381

Улаанбаатар
хот

Нээлттэй засгийн түншлэлийн тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийг үндэслэн, олон улсын Нээлттэй засгийн түншлэлд Монгол Улс нэгдэн орсонтой холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газар, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтран хэрэгжүүлэх “Нээлттэй засгийн түншлэлийн үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө”-г зарчмын хувьд сайшаан дэмжсүгэй.

2. “Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай” Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 98 дугаар тогтоолын 19 дүгээр хавсралтад дараах агуулга бүхий 24 дэх заалт нэмсүгэй:

24.	Нээлттэй засгийн түншлэлийн Үндэсний зөвлөл	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
-----	---	---

3. Нээлттэй засгийн түншлэлийн үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөг хэрэгжүүлэх болон зохион байгуулалтын арга хэмжээнд шаардагдах зардлыг 2014 оны улсын төсвийн тодотголд тусган санхүүжүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэг, Сангийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

4. Нээлттэй засгийн түншлэлийн үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөг баталж, түүнд тусгагдсан асуудлыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Нээлттэй засгийн түншлэлийн Үндэсний зөвлөлийн дарга Ч.Сайханбилэгт үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Н.АЛТАНХУЯГ

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга

Ч.САЙХАНБИЛЭГ